

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 08 дугаар 25 сарын

Мандалговь хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийгдэж буй хяналт-шинжилгээний зорилго нь төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад эдийн засгийн хувьд үзүүлж буй үр нөлөөний талаар иргэдийг мэдээллээр хангах төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийхэд аймгийн хэмжээнд 2024 онд гадаадын хөрөнгө оруулалттай 8 төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт амжилттай хэрэгжиж байна.

**“Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр”**

№	Төслийн нэр	Санхүүжүүлэгч байгууллага	Хэрэгжиж буй салбар	Төслийн хэрэгжих хугацаа	Нийт санхүүжилтийн хэмжээ /сая,төгрөг/	2024 оны хөрөнгө оруулалтын хэмжээ /сая,төгрөг/
1	“Ундны цэвэр ус”	Бүгд Найрамдах Солонгос Улсын “COVA” Олон улсын байгууллага	Боловсрол	2023-2024	Тодорхойгүй	6.0
2	Адаацаг суманд бэлчээрийн менежментийг сайжруулах төсөл	Ю-Пи-Си Реньюбелс Монголиа ХХК	Хөдөө аж ахуй	2023-2028	Тодорхойгүй	80.0
3	Өлзийт суманд “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл” хэрэгжүүлэх	Германы хөрөнгө оруулалттай KFW банк	Боловсрол	2024-хугацаагүй	Тодорхойгүй	66.0

4.	Уур амьсгалд тэсвэртэй орон нутаг	“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага	Хөдөө аж ахуй	100	100	99.6
5.	“Үдийн хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” төсөл	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)	Боловсрол	2022-2025	Тодорхойгүй	20.0
6.	Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл	Японы сан	Хууль эрхзүй	2023-2024	43,8	21,9
7.	Дулааны станц	БНСУ-ын “Экспорт, импорт” банк	Эрчим хүч	2022-2025	Тодорхойгүй	Тодорхойгүй
8.	Зуны гэр цэцэрлэг, гэр сургууль төсөл	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан	Боловсрол		Тодорхойгүй	8,4

## БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛТ ХӨТӨЛБӨР

### “Ундны цэвэр ус”

“Ундны цэвэр ус”, Бүгд Найрамдах Солонгос Улсын “COVA”, Олон улсын байгууллагын төсөлт хөтөлбөр дотуур байранд шинээр ус цэвэршүүлэгч шүүлтүүрийг хүлээлгэн өгсөн. Төсөл хэрэгжснээр хүүхэд цэвэр ус уух боломжоор бүрэн хангагдсан ба Адаацаг сумын дунд сургуулийн дотуур байрны нийт 70 хүүхэд төслийн үр шимийг шууд хүртэж байна.

### “JICA” ОУБ-ын хэрэгжүүлж буй Монгол улсын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл

1. Мандал, Говийн ирээдүй цогцолбор сургуулиудад үдийн хоол үйлдвэрлэлийг жишиг болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд тус хоёр сургуулийн гал тогоонд нэн шаардлагатай байгаа 20 нэр төрлийн 92.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг төслийн удирдагч Морито Утако өөрийн биеэр ирж ашиглалтыг шалган хүлээлгэн өглөө. Уг ажлын нийлүүлэгчээр “Тулга төхөөрөмж” ХХК хамтран ажилласан.



2. Сургуулийн үдийн хоолыг иж бүрдэл маягаар өгөх зорилгын хүрээнд Мандал сургуульд 700 ширхэг, ГИЦС-д 500 нийт 1200 ширхэг шөлний аягыг нийлүүллээ. Энэхүү аяга нь сурагчдын хоолонд зориулагдсан стандарт хэмжээтэй бөгөөд халуунаа барихаас гадна сурагчдын гар халах эрсдэлээс сэргийлэх юм.



3. Мандал, Говийн ирээдүй сургуулиудад хүнсний ногоо хөлдөөх зориулалтын хөлдөөгч тус бүр 1-ийг хүлээлгэн өгснөөр нарийн ногоог хөлдөөж шим тэжээлийг нь алдагдуулахгүйгээр хадгалах боломжийг бүрдүүллээ.



4. Жайка ОУБ-ын хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-д хамрагдаж буй Говийн Ирээдүй, Мандал сургуулиуд нь сургуулийн дэргэдэх туслах аж ахуйдаа төслийн санхүүжилтээр 5.5 сая төгрөгний өртөг бүхий 8:6 харьцаатай гурван улирлын хүнсний ногоо тариалах боломжтой хүлэмжтэй боллоо.



5. Хүнсний ногооны хэрчилтийн арга техник, хүнсний ногоогоор хоолыг баяжуулахын хэрэгцээ шаардлага, эрүүл мэндэд нөлөөлөх ач тусын талаарх онолын мэдлэг, хүнсний ногоог ашиглах түүн дотроо орон нутгийн онцлогтой ногоогоор баяжуулсан хоол, хачир, жимсний компот хийх технологи, чадварыг эзэмшүүлэх зорилготой сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 26ны өдөр ЖАЙКА ОУБ-ын "ЕБС-ийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл"-тэй хамтран зохион байгуулж нийт 15 сумын 84 хоолзүйч, тогооч нар оролцсон. Онолын мэдлэгтээ үндэслэн орон нутагт тариалагдаж буй бууцай, нарийн шар хулуу, нарийн ногоон хулуу, лууванг ашиглан зутан шөл хийх, жимсний компот хийх, ногоо хөлдөөх аргаас суралцан дадлага ажил хийлээ. Сургалтын нийт зардал 4.6 сая төгрөг.




**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН МАЛЧДЫН ХҮҮХДЭД ЗОРИУЛАН “НҮҮДЛИЙН ЦЭЦЭРЛЭГ”-Т ХИЙГДСЭН АЖЛУУД**

Тус цэцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд сумын хэмжээнд 2-5 насны 507 хүүхдийн 300 хүүхдийг өдрийн 10 бүлгийн сургалтанд, 48 хүүхдийг явуулын багшийн сургалтанд хамруулж СӨБ-ын хамран сургалт 68.6%-тай байсан. Цэцэрлэгт хамрагдаагүй малчдын хүүхдэд СӨБ олгох, хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор бсарын 3-наас 4 багт “Нүүдлийн бүлэг”-ийг хичээллүүлж 83 хүүхдийг хамруулж 2024 оны 07 сарын байдлаар СӨБ-ын хамран сургалт 85%-тай байна.


**Өнгөт багийн гэр цэцэрлэгийн** 21 хоногийн сургалтад 20 хүүхэд хамрагдсан. Үүнээс 3 наст- 7 хүүхэд буюу 35%, 4 наст- 1 хүүхэд буюу 5%, 5 наст – 12 хүүхэд буюу 60% байна. графикаар харуулвал

Тэнгэлэг багийн Гэр цэцэрлэгт 3-5 насны огт цэцэрлэгт хамрагдаагүй 23 хүүхдийг хамруулсан.






Рашаант багийн 3-5 насны огт цэцэрлэгт хамрагдаагүй 20 хүүхдийг хамруулсан. Үүнээс



эрэгтэй 10 , эмэгтэй 10 хүүхэдтэй

Сангийндалай багийн 3-5 насны огт цэцэрлэгт хамрагдаагүй 20 хүүхдийг хамруулсан. эрэгтэй 11 , эмэгтэй 9 хүүхэдтэй Нийт 2023-2024 оны хичээлийн жилд Нүүдлийн



бүлэгт малчдын цэцэрлэгт огт хамрагдаагүй 83 хүүхдийг хамруулж СӨБ-ын хамран сургалт 85%-тай болж нэмэгдсэн.



Нүүдлийн гэр цэцэрлэгт хамгийн ойр нь 3км-с, хамгийн хол нь 22км-с хүүхдүүдээ зөөдөг байна. Баг бүр дээр 3-5 хүүхэд орой хонодог байсан.

Өмнө нь цэцэрлэгт явж байгаагүй хүүхэд нийгэмшгүйн болон оюун ухааны, эрүүл ахуйн хүмүүжлээр хоцорч бие бялдар, эрүүл мэндийн хүмүүжил төвийн хүүхдүүдийг бодвол илүү сайн байсан. Эцэг эх асран хамгаалагч нартай нь хамтран ажилласнаар хүүхдийн хөгжлийн хоцрогдол арилсан гэж дүгнэж байгаа. Малчдын хүүхдийг тоглоомоор дамжуулан хөгжүүлэх үйл ажиллагааг явуулснаар хүүхдийн танин мэдэхүйн чадвар илүү хөгжиж, багш туслах багшийн туслалцаатай эрүүл мэндийн боловсролыг түлхүү сайн оруулсан нь хүүхдийг бохир гарын өвчлөл, шүдний болон хоолой амны төрөл бүрийн өвчлөлөөс хамгаалж ажиллаа.

### Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөлт хөтөлбөр

Тус төслийн хүрээнд Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуульд 66 сая төгрөгийн өртөг бүхий “Эко кабинет”-ыг байгуулав. Төсөл хэрэгжүүлэх арга зүйн сургалтад сургуулийн захирал, хими биологийн багш нар хамрагдаж сургалтын хэрэглэгдэхүүн, компьютер, тавилга, тоног төхөөрөмж ширээ сандал зэрэг 43 нэр төрлийн эд хөрөнгийг хүлээн авч кабинетыг тохижуулав.

## Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төсөлт хөтөлбөр

### Эрдэнэдалай суманд 5 га талбайд Тэжээлийн ургамал тариалалт

2023-2024 онд Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төслийн санхүүжилтээр Эрдэнэдалай суманд 10 малчин өрх нэгдэж "Далайн шим" малчдын бүлэг байгуулан 5га талбайд тэжээлийн ургамал тариалахаар малчдын бүлгийн гишүүд хамтран ногоон тэжээл тариалах талбайг хашиж, хөрс боловсруулалт, тариалалтын ажлыг 2023 оны 04-07 дугаар сараас хийж хэрэгжүүлсэн.

Мөн малчид тэжээлийн ургамал тариалахаас гадна дараах арга хэмжээг хэрэгжүүлж, шинэ мэдлэг, ур чадвар эзэмшиж авсан.

**Мод тарих, хамгаалалтын зурвас байгуулах:** Бүлгийн зарим гишүүд талбайнхаа хамгаалалтыг сайжруулах зорилгоор мод тарьсан.

**Өвөлжөө, хаваржааны бууцан дээр тэжээл тарих, хөрсгүй тариалах туршилт:** Малчид өвөлжөө, хаваржааны бууц ашиглан тэжээл тариалах, хөрсгүй тариалалтын туршилтыг амжилттай хийж суралцсан нь чухал давуу талтай байлаа.

Тариалалтын явцад малчид дараах ур чадваруудыг эзэмшиж байна:

**Тариалалтын технологи:** Анжис, хөрс сийрүүлэгч, үрлэгч трактор зэрэг тоног төхөөрөмжийн угсралт, тохируулга хийх, газар хагалгаа, хөрс боловсруулах, усалгааны



систем суурилуулах зэрэг технологийн ур чадварыг малчид эзэмшиж эхэлсэн. Говийн бүс нутагт тариалалт хийх туршлагатай малчид цөөн байсан тул энэ мэдлэг чухал байв.

**Бүлгийн хамтын ажиллагаа:** Бүлгээрээ нэгдэн хамтарч ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэхэд суралцсан нь ажлын үр дүнг нэмэгдүүлж Бүлгүүд овъёос, арвайг хольж тариалсан бөгөөд эдгээр ургамлууд нь шимт чанар сайн уургийн агууламж өндөртэй, тул малын энергийг нөхөх, тэжээллэг чанар сайтай тэжээл болж байна. Говийн бүсийн малч ид бэлчээрийн хадлан бэлтгэх боломж хомс тул 5 га талбайд тариалсан тэжээлийн ургамлаа өвлийн улиралд малын тэжээл болгон ашиглах боломжтой болсон нь чухал дэвшил юм.



Энэхүү арга хэмжээ нь малчдыг өндөр үнэтэй өвс худалдан авах шаардлагаас чөлөөлж, өрхийн амьжиргаанд эергээр нөлөөлж байна. Эрдэнэдалай суманд өнгөрсөн жил нэг боодол өвс 30,0 мянган төгрөгт хүрч, намрын улиралд 15-20 мянган төгрөгийн үнэтэй байсан. Бүлгийн ахлагчийн тооцоолсноор, одоогийн ургац нь 10 -15 сая төгрөгийн үнэ бүхий ногоон тэжээл болохоор байна. Энэ арга хэмжээ нь малчдын орлого нэмэгдэж, эдийн засгийн чадавхи сайжирч тэжээлийн хангамжийг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.



#### Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц

Дундговь аймгийн дулааны станц барих төсөл"-ийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан инженеринг” компани шалгарч /туслан гүйцэтгэгчээр байгууллагаар “Энерго сервес монтаж ХХК”/ 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээнд төслийг 26.5 сарын хугацаанд гүйцэтгэхээр тусгасан бөгөөд 2024 оны 12 дугаар сард дулааны станцыг ашиглалтад оруулах байсан боловч төслийн хэрэгжилтийн явцад гүйцэтгэгч “Бьюксан инженеринг” компанийн зүгээс “дэлхий нийтийг хамарсан цар тахал, Украин-Оросын дайны үүдэлтэйгээр бараа материал, тоног төхөөрөмжийн үнийн өсөлт үүсэж, компани санхүүгийн хүндрэлд орсон” гэж мэдэгдсэн

Санхүүжилтийн төсөвт өртөг:10,096,675 ам.доллар /гүйцэтгэгчид олгосон санхүүжилт-5,082,999 ам.доллар(50%)/Төсөл хэрэгжиж дуусах хугацаа: 2024.12.05  
Төслийн хэрэгжилт:Зураг төсөл-86.56% Худалдан авах ажиллагаа - 47.47хувьтай байна .

2024 онд Дулааны станцын угсралтын ажил зуух угсралт усан шахалт хийхэд бэлэн болсон, үндсэн барилгын краказ  $\frac{1}{3}$  хэсэг, цахилгааны дэд станц барилга, нүүрс хүлээн авах барилгуудын цутгалтын ажил, конвейр 1, нүүрс бутлуур, утаа сорогчын суурийн цутгалтын хийж дуусан. Ажлын гүйцэтгэл 45% байна.



**“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь баривчлагдсан этгээдэд зохион байгуулах албадан сургалтын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Азийн хөгжлийн банк хамтран Японы сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн 21,9 сая төгрөгийн санхүүжилтээр Баривчлах байрны сургалт, сэтгэл зүйн өрөөг тохижууллаа.

Мөн хоригдол, баривчлагдсан этгээдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эерэг уур амьсгал бүрдүүлж, тэдний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах зорилгоор номын сандаа “Цахим номын сан”-г бий болгосон.

Сургалтын танхимыг тохижуулснаар баривчлагдсан этгээдэд зохион байгуулах орчин нөхцөлийг бүрэн бүрдүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.



## ДҮГНЭЛТ

Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээг хийлээ. Аймгийн хэмжээнд 2024 онд гадаадын зээл тусламжаар орон нутгийн хэмжээнд Гадаадын хөрөнгө оруулалттай 8 төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.Он дамжиж гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн 4 төсөлт хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.Үүнд

Боловсролын салбарт Гадаадын зээл тусламжаар 4 төсөлт хөтөлбөр 100.4 сая төгрөгийн санхүүжилттэй үр дүнтэй хэрэгжсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн“Ундны цэвэр ус”, Бүгд Найрамдах Солонгос Улсын“COVA”,Олон улсын байгууллагын төсөлт хөтөлбөр дотуур байранд шинээр ус цэвэршүүлэгч шүүлтүүрийг хүлээлгэн өгсөн байна. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл"- д хамрагдаж сурагчдын эрүүл аюулгүй, шим тэжээлтэй хоол хүнсээр хангагдах боломж бүрдэж Улсын хэмжээний жишиг орчин нөхцөл бүрдэж, үдийн хоол үйлдвэрлэлийн менежментийг сайжруулсан байна.

Эрдэнэдалай сумын хүүхдийн цэцэрлэгийн малчдын хүүхдэд зориулан“ нүүдлийн цэцэрлэг”-т хамруулснаар бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжсэн, хэрэгцээ, сонирхолд нийцсэн, эрүүл аюулгүй сурч боловсрох таатай орчинг бий болгосон. Малчдын хүүхдийн нэгдүгээр ангид ороход бэлтгэж хоцрогдолгүй сурах боломжийг бүрдүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарт Гадаадын зээл тусламжаар 2 төсөлт хөтөлбөр 179.6 сая төгрөгийн санхүүжилттэй үр дүнтэй хэрэгжсэн байна. Адаацаг суманд бэлчээрийн менежментийг сайжруулах төсөл Ю-Пи-Си Реньюбелс Монголиа ХХК-ны хөрөнгө оруулалтаар бэлчээрийг нөхөн сэргээх, хаших ажлыг эхлүүлсэн байна. Уур амьсгалд тэсвэртэй орон нутаг Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.

Хууль эрх зүйн салбарт “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн 21,9 сая төгрөгийн санхүүжилтээр сургалт зохион байгуулах“ сургалтын танхим”-ыг тохижуулж орчин нөхцөлийг сайжруулсан төсөлт хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэн байна.

## **ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭСТ /ЗӨВЛӨМЖ/**

1.Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн төсөл бичих арга зүйн дэмжлэг, сургалт зөвлөгөөг холбогдох хэлтэс, агентлагуудад өгч хамтран ажиллах.

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөлт хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг иргэд олон нийтэд ил тод, хүртээмжтэй тайлагнах.

3.Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланг тайлагнахдаа хийгдсэн ажлыг дэлгэрэнгүй нотлох баримттай тайлагнах.

## **ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**